# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

(Шинэжинст сум)

2024 оны 06 дугаар сарын 20

Залаа

| Шийдвэр Д/д | Заалт Д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц | Өөрийн үнэлгээ | Дээд шатны байгууллагын үнэлгээ | Үнэлгээний тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| | | | МУ-ын хууль | | | | |
| 1 | 1 | Ойн тухай /Шинэчилсэн найруулга/ 2012-05-17 Дугаар 2022.06.03 | 39.7. Ой, хээрийн түймрээс хамгаалах арга хэмжээний зардлыг аймаг, сум, нийслэл, дүүрэг жил бүрийн төсөвтөө тусгана. | Тус сум нь заган ой бүхий сум учир ой хээрийн түймэр гарах эрсдэл үүсэх магадлал бага учраас тусгайлан төсөв санхүү тусгаагүй ч урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээллийг иргэдэд цахимаар хүргэж ажилласан. | 70% | 70% | |
| 2 | 2 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01 | 18.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хөтөлбөр боловсруулах талаар судлагдаж байна. | 70% | 70% | |
| | 3 | | 18.1.2.. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг батлуулаагүй. | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | | | | |
| | 4 | | 19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хууль тогтоомжийг сурталчлах, иргэдэд энэ чиглэлийн мэдлэг мэдээллийг олгох үүднээс цагдаагийн хэсэгтэй хамтран 6 удаагийн сургалт зохион байгуулж 400 гаруй иргэдийг хамруулсан. Гэр бүлийн зөрчил маргаан гаргасан, гаргаж болзошгүй иргэдтэй өөрийн хүсэлтээр ганцаарчлан уулзаж зөвлөлдөх, хөдөлмөр эрхлэх болон ажлын байраар хангах зэрэг боломжит арга хэмжээг авч ажиллаж байна. | 70% | 70% | |
| | 5 | | 19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж төлөвлөгөөт хурал 4 удаа, шуурхай хурлыг 2 удаа зохион байгуулж холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна. | 70% | 70% | |
| | 6 | | 19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөвт тодотголоор батлуулахаар төслийг боловсруулж бэлтгэсэн бөгөөд сумын ИТХ-ын хагас жилийн хурлын хуралдаанаар оруулах шаардлага байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс болсон. | 30% | 30% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | | | | |
| | 7 | | 19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөвт тодотголоор батлуулахаар төслийг боловсруулж бэлтгэсэн бөгөөд сумын ИТХ-ын хагас жилийн хурлын хуралдаанаар оруулах шаардлага байна.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс | 30% | 30% | |
| | 8 | | 19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ: | Нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс сумын хуучин соёлын төвд нэг өрөөг тохижуулсан. | 70% | 70% | |
| | 9 | | 19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх | Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн, хүмүүнлэгийн сэтгэл зүйч Г.Бандицэрэнг урьж 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр ард иргэд, сурагчдад сургалт зохион байгуулж ажиллалаа. мөн сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг 6 хүнд өгсөн. Тус арга хэмжээнд 2 сая төгрөг зарцуулсан. | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | | | | |
| | 10 | | 19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:) | Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн хүрээнд хийсэн төлөвлөгөөний дагуу сургалт арга хэмжээ 6 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 670 гаруй иргэд хамрагдсан байна. | 70% | 70% | |
| 3 | 11 | Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01 | 55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ. | Төрийн албан мэдлэг чадварыг нэмэгдүүлэх хүрээнд Тамгын газар 2024 онд 5,000,000 төгрөгийг томилолтын зардалд төсөвлөсөн. Хагас жилийн байдлаар нийт 2,500,000 төгрөгийг зарцуулсан байна. Мөн байгууллагын сургалтыг дотооддоо зохион байгуулж, сар бүр төлөвлөгөө гарган ажиллалаа. Эрүүл мэндийн төвтэй хамтран 04 дүгээр сарын 29-ний өдөр Урьдчилсан үзлэгт хамрагдаагүй 16 албан хаагчийн нэг талын зардлыг Тамгын газраас гарган хамрууллаа. | 70% | 70% | |
| 4 | 12 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай /Шинэчилсэн найруулга/ 2020-05-07 Дугаар 2020.07.01 | 7.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоо нь улсын түвшинд үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, салбарын түвшинд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагууд, орон нутгийн түвшинд аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэдэх | 2024 оны сумын Хөгжлийн төлөвлөгөөг Засаг даргаар батлуулан ажилладаг бөгөөд сумын хууль эрх зүйн мэргэжилтэн хэрэгжилтийг хангуулан хяналт тавьж ажиллан хагас бүтэн жилээр хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна | 100% | 100% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хөгжлийн бодлого, төлөвлөлтийн нэгж, сумын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал хариуцсан ажилтнаас бүрдэнэ. | | | | |
| УИХ-ын тогтоол | | | | | | | |
| 5 | 13 | Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 19, 20 дахь илтгэлийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2021-07-07 Дугаар 2021 №67 | 1.1.ж/. цар тахлын үед хүүхэд, зорилтот бүлгийн иргэдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгааллын байцаагчийн тоог нэмэгдүүлэх, хүүхэд хамгааллын асуудалд нэн шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг ямар ч нөхцөлд хасахгүйгээр, цогц байдлаар төсөвлөх, шаардлагатай тохиолдолд төсвийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх; (1/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагаанд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр:) | Сумын Засаг дарга харьялах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг төсвийн тодотголоор оруулах боломжийг судалж байна<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас | 30% | 30% | |
| УИХ-ын байнгын хорооны тогтоол | | | | | | | |
| 6 | 14 | Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний | 2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад | Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөл, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ | шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих. | тархалтыг иргэн, гэр бүл, байгууллага хамт олонд тулгуурлан зогсоох, түүнээс урьдчилан сэргийлэх, өвчний эрт үеийн хяналт, тандалтыг сайжруулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, уур бухимдал, сэтгэл гутрал, стрессээс сэргийлэх, өөрийгөө хянах аргачлалыг тодорхойлж, зөвлөгөө өгөх сэтгэл заслын эмчилгээг эрүүл мэндийн нийгмийн ажилтан И.Ууганбаяр фейсбүүк, цахим захидал ашиглан ард иргэдэд түгээж ажилласан. Эрүүл орчинтой ажлын байрыг дэмжин байгууллага, аж ахуй иргэдэд сургалт хийж ажилласан. Цусны даралт ихсэх эрт илрүүлэг үзлэгт 1594 иргэн харагдахаас 291 буюу 18,2% хамрагдсан байна. Үүнээс давтан үзлэгт хамрагдсан 9, оношлогдсон артерийн гипертензи 3 хувийг эзэлж байна. Эмийн эмчилгээнд хамруулан хяналт тавин ажиллаж байна. Чихрийн шижингийн хэв шинж-2 эрт илрүүлэг үзлэгт 929 иргэн хамрагдахаас 236 буюу 25,4% хамрагдсан. Мөн эдгээр оношлогдсон иргэдэд зөв зохистой хооллолт, хоолны илчлэгийг тооцох арга аргачлал, амьдралыг хэв маягаа өөрчлөх, хорт зуршлаас татгалзах, идэвхтэй хөдөлгөөн зэрэг сэдвээр зөвлөмж бэлтгэн танилцуулсан. Хөх, умайн хүзүү эрт илрүүлэг шинжилгээд 159 хамрагдахаас 39 буюу 24,5% хамрагдсан байна. Хөх, умайн хүзүүний өөрчлөлттэй өвчлөл бүртгэгдээгүй. Хөдөлмөрийн чадвар түр алдалт, мэргэжлээс шалтгаалах өвчлөл, тэдгээрийн шалтгааныг эрт илрүүлэх, бүртгэх, тандах, мэдээлэх арга хэмжээг хэрэгжүүлэн мэдээллийн сан үүсгэсэн байна. | | | |
| 7 | 15 | “Монгол Улс дахь хүний эрх, эрх | 3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх,. | Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр урьдчилан сэргийлэх | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл"-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ | хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах | чиглэлийн сургалтуудыг мэдээллийн цагаар тогтмол зохион байгуулсан бөгөөд Хүмүүнлэгийн сэтгэл зүйч Чила буюу Г.Бандицэрэн докторыг урьж Амьдралын үнэ цэнэ сургалтыг гэрээ байгуулан 2 сая төгрөгийн төлбөр төлж зохион байгуулан 130 гаруй иргэд, 240 гаруй сурагчдыг хамруулсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажиллаж байна. Нийгмийн бодлогын мэргэжилтнийг төрийн албаны зөвлөлийн сонгон шалгаруулалтад орж тэнцсэн ажилтныг авч ажиллуулж байна. | | | |
| 8 | 16 | Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2022-04-13 Дугаар 2022 №04 БОХХААБХ | 1.5/. Мал амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээний хүрээнд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль болон Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэгжүүлж, хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд огцруулах хүртэл хариуцлага тооцох; | Мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд сумын хэмжээний 436 үхэр сүрэг хамрагдлаа.Энэ арга хэмжээг 05 сарын 20 -ноос 06 сарын 20 хүртэл хугацаанд хийж гүйцэтгэлээ. | 70% | 70% | |
| | 17 | | 1.6/. Малын тоо толгойн албан татварын 50-аас доошгүй хувийг малын эрүүл мэндийг хамгаалах, | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй. | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх; | | | | |
| 9 | 18 | Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ | 1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх; | Сумын хэмжээнд 222 ахмад настангуудын судалгаа гарсан. Хүүхдийн Цэцэрлэгийн хуучин барилгыг ахмадын өргөөний зориулалтаар ашиглаж байсан боловч засвар үйлчилгээ хийх шаардлагатай болсон өрөө тасалгаа жижигхэн тул бүрэн их засвар хийгдсэн хуучин Соёлын төвийн барилгыг "Ахмадын өргөө"-гөө болгон ахмадуудад хүлээлгэн өгч тогтмол үйл ажиллагаа явуулж байна. | 70% | 70% | |
| 10 | 19 | Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэсийн баталгаажуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-01-17 Дугаар 2023 №03 БОХХААБХ | 1.4/. Тусгай хамгаалалттай газар нутагт Нийслэл, дүүрэг, сумын Засаг даргын захирамжаар газар эзэмших, ашиглах эрх олгосон болон Нийслэлийн нутаг дэвсгэрт Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар газар эзэмших эрх олгосон асуудлыг хуульд нийцүүлэн шийдвэрлэж, газрын эрхийг гэрчилгээ олгох, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах; | Тодорхой ажил хийгдээгүй<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас | 0% | 0% | |
| Ерөнхийлөгчийн зарлиг | | | | | | | |
| 11 | 20 | Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туай 2018-05-23 Дугаар 2018_46 | 3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн | Соёлын төвийн гадна хаяг болон дотор өрөөний хаалгыг монгол бичиг болон кирилл бичгээр хослуулах хийсэн хаалганы хаяг нэг бүрийг нь 6000 төгрөг, гадна хаяг 150000 төгрөгөөр хийлгэж байрлуулсан. | 100% | 100% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай. | | | | |
| 12 | 21 | Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58 | 1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох | Тус сумын төвд ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн орон нутгийн хөгжлийн сангийн тэрбум гаран төгрөгийн санхүүжилттэй тендерийн ажил өрнөж байна. Мөн сумын төвд гүн өрмийн Цагаан худгийг түшиглэн мод тарих, цаашид цэцэрлэгт хүрээлэн байхаар төлөвлөн ажиллаж байгаа бөгөөд 1800 ширхэг мод таригдлаа. Мод тарих соёлыг сурталчлан таниулах, хамтран мод тарих ажлуудыг 58 өрхийн хамт хийсэн. | 100% | 100% | |
| | 22 | | 2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай. | Байгалиа хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд хувь нэмэр оруулах тухай зөвшилцсөний дагуу Эрдэнэмонгол ХХК Уртын гол 2 дугаар багт 800, Эрдэнэшанд багт 3000, Эхэнхавцгай 4 дүгээр багт 1800, Эхийн голд 6800 ширхэг мод тарихаар хувь иргэдтэй гэрээ байгуулан тариуллаа. Сэкер ресорсус Монголиа ХХК сумын төвийн ойн зурваст 2500 ширхэг мод тарьж хамтран ажилласан дүнтэй байна. | 70% | 70% | |
| 13 | 23 | Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159 | 3. Монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг уриалсугай. | уг хэрэгжилтийн хүрээнд сумын ЗД-ын ажлын албан өрөөнд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байна. мөн монгол хүн, айл өрх бүр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг эрхэмлэн залж, дээдлэн шүтэж байхыг нийт ард иргэдээ багийн хурал ,болон сургалт болгон дээр уриалан ажиллаж байна. | 70% | 70% | |
| ҮАБЗ-ийн зөвлөмж | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 14 | 24 | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03 | 3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах. | Бүх нийтээр мод тарих хаврын мод тарилтаар "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулж, 160 гаруй иргэн хамрагдаж, нийт 14800 ширхэг модны суулгацыг газрын хөрсөнд суулгасан дүнтэй байна. Үүнд "Сэкер ресорсус" ХХК 2500 суулгац, ЭрдэнэМонгол ХХК 11600, Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслөөс 800 ширхэг суулгац, ЗДТГ-аас 860 ширхэг нийт 14800 суулгацыг бэлтгэн шинээр тариад байна. Мөн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас 15 га газарт 26000 ширхэг заг хайлаас сухай тарихаар ирсэн бөгөөд Уртын гол 2 дугаар багийн нутаг Баянбулаг гэх газарт ажлыг эхлүүлсэн, ажлын явцад хяналт тавьж ажиллаж байна. | 70% | 70% | |
| ЗГ-ын тогтоол | | | | | | | |
| 15 | 25 | Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7 | 5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан | Соёлын төв нь албан бичиг болон даргын тушаалыг монгол бичиг крилл бичгээр хослуулан гаргаж байна. мөн байгууллагын хаяг өрөөний хаягийг хос бичгээр хийсэн болно. Засаг даргын Тамгын газар монгол бичгийн хэвлэмэл хуудсуудыг төрийн архивт захиалан авч харилцагч байгууллагуудтайгаа крилл монгол хосолсон бичгээр харилцаж эхлээд байна. | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр батлаж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх. | | | | |
| 16 | 26 | Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай 2023-07-19 Дугаар 2023_279 | 2.. 2.5.Энэ тогтоолын хавсралтаар батлагдсан аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, аймгийн төвийн хүн амын хаврын улирлын махны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээ авах, отор нүүдлийг тогтоосон чиглэлийн дагуу явуулах, мал эмнэлгийн хорио цээрийн хяналт шалгалтыг эрчимжүүлж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт; | Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зорилгоор Сумын Засаг даргын захирамжийг хэрэгжүүлж төлөвлөгдсөн төсвийн хүрээнд тендерийн техникийн тодорхойлолтыг гарган тендерийг зарлуулан гүйцэтгэгчийг шалгаруулан 30 тн өвс, 53,9 тн тэжээлийг хүлээн авч нөөцийг бүрдүүллээ. Бэлчээрийн даацтай уялдуулан мал мах бэлтгэх ажлыг зохион байгуулах талаар иргэдэд сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компанид 3000 толгой ямааг орон нутгийн ханшаар худалдааллаа. Эдгээр арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд өвөлжилтийн бэлтгэл 85,4 хувиар хангагдсан болно. Өөр аймаг болон өөрийн аймагт отроор яваа өрхүүд тухайн нутагтаа өвөлжиж,хаваржиж, зусаж байна. Малын шилжилт хөдөлгөөнийг 12 дугаар сарын 31 хүртэл хориглох тухай аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангах ажлыг сайн зохион байгуулсны үр дүнд хөдөө аж ахуйн | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | салбар харьцангуй бэрхшээл багатай даван туулж байна. Монгол улсын засгийн газраас авч явуулж байгаа арга хэмжээг орон нутагт зохион байгуулах, хэрэгжилтийг хангаж байна. Орон нутгийн давсан орлогыг засаг даргын нөөцөд тодотголоор оруулан нэмэгдүүлж, сумын Онцгой комиссын шийдвэрээр 2000 боодол өвс татаж малчдад үнэгүй олголоо. Мөн Монгол улсын засгийн газраас хуваарилсан 22 тн улаан буудай, 2 тн гурил, 200 кг сахрыг татан авч малчдад хүргэлээ. Гадныг аймгийн нутагт 4 өрх, өөрийн аймгийн сумдад 3 өрх оторлож байна. Отորт яваа өрхүүдэд мөнгөн дэмжлэгийг олголоо. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг цаг тухай бүрд авч хяналтыг сайжруулан тандалт хийн ажиллаж байна. Өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажилд сумын Орон нутгийн хөгжлийн сан дээр батлагдсан 65230000 төгрөг, Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2023 оны үлдэгдлээс 54000000 төгрөгийг тодотгож нөөц бүрдүүлэн малчдыг эрсдэлээс хамгаалан ажилласан. Ард иргэд, аж ахуйн нэгжийн хандив тусламжаар 38920,0 сая төгрөг төвлөрч сумын онцгой комиссын шийдвэрээр зарцуулсан. | | | |
| 17 | 27 | Улсын хэмжээнд 2024 онд эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт батлах тухай 2024-04-03 Дугаар 2024_136 | 2.. Энэ тогтоолоор баталсан жагсаалтад тусгагдсан байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах шийдвэр гаргахдаа газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээр дамжуулан хэрэгжүүлэх арга хэмжээ авч, жагсаалтад тусгагдаагүй байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах аливаа шийдвэр гаргахгүй байхыг | Засгийн газрын 2024 оны 136 дугаар тогтоолтой танилцаж жагсаалтад тусгагдаагүй байршилд газар олгохгүй байх талаар сумын удирдлага, иргэдэд мэдээлэл өгч ажиллаж байна.Жагсаалтад тусгагдсан байршилд захирамж шийдвэр гаргахаар иргэдээс өргөдөл хүлээн авч байна. Өвөлжөө хаваржааны зориулалтаар газар эзэмшүүлэхээр нийт 16 иргэнээс өргөдөл авч захирамжийн төсөл орсон газрын кадастрын мэдээллийн сангаас холболт хийхээр хүлээгдэж байна. Газрын кадастрын | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, сум, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай. ("Улсын хэмжээнд 2024 онд иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар болон төрийн байгууллагад эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралт, "Аж ахуйн зориулалтаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт, "Улсын тусгай хамгаалалттай газарт ашиглуулах газрын байршил, хэмжээ, зориулалтын жагсаалт"-ыг 3 дугаар хавсралт) | мэдээллийн санд нь цахим өргөдөл авч байгаатай холбогдуулан агентлагаас засварлах ажил хийгдэж байна. | | | |
| 18 | 28 | Зүй бусаар хорогдсон малын сэг зэм устгах, мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зарим арга хэмжээний тухай 2024-04-24 Дугаар 2024_173 | 1.. Хүн, мал, амьтны халдварт өвчин дэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг зохих журмын дагуу устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийх арга хэмжээг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор зохион байгуулахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай | Малын сэг зэм устгах ажлыг 04 дүгээр сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулан ажиллаж 330 малын сэг зэмийг ажлын хэсгээр явж устгал хийж халдваргүйтгэл хийлээ. | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | 29 | Хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай 2024-05-01 Дугаар 2024_187 | 4.б.. Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд эзэмшүүлэх газрыг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж, газар эзэмшүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга нарт, тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөлд тухай бүр нь дүгнэлт гаргаж ажиллахыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар (А.Энхманлай)-т тус тус даалгасугай | Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан 2024 онд мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх зориулалтаар малчдын хоршоонд газар эзэмшүүлэх талаар мэдээлэл өгсөн. Шинээр 3 хоршоо байгуулагдахаар бичиг баримтаа бүрдүүлж байна. Албан ёсоор улсын бүртгэлийн гэрчилгээ авсан 1 хоршоо байна. Тост толгой хайрхан хоршооноос малын гаралтай түүхий эд авах цэг, агуулах, зоорь барих 5 га газар хүссэн хүсэлтийг 2024 оны 06 дугаар сарын 18 өдөр өгсөн. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлдэж байна.<br><br>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас | 30% | 30% | |
| 20 | 30 | Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим системийн талаар авах арга хэмжээний тухай 2024-05-08 Дугаар 2024_196 | 3.. "Засгийн газрын хүний нөөцийн бодлогыг дэмжих цахим систем"-ийг ашиглан эрхлэх асуудлынхаа хүрээндээ төрийн албан хаагчийн мэдээллийн бүрдүүлэлт, үнэн зөв байдалд хяналт тавьж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай | https://hrm.csc.gov.mn/hrsuite/employee сайтыг хөтлөн ЗДТГ-ын төрийн алба хаагчдын мэдээллийг цаг тухай бүрт оруулан шинэчилж ажиллаж байна. Уг программд бүртгэлтэй 25 ажилж байгаа албан хаагч байна. | 100% | 100% | |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 21 | 31 | 2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28 | XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов. | Ард иргэдэд цахим гарын үсгийн тухай хуулийн талаар мэдээ мэдээллийг тогтмол хүргэж тоон гарын үсэгтэй болох давуу тал, хэрэглээний талаар сурталчлан таниулж өмнөх 2023 онд 16-аас дээш насны 1642 иргэнээс 1579 иргэн буюу ард иргэдийн 96,2 хувь нь тоон гарын үсэгтэй болсон байна. Ард иргэдийн тоон гарын үсгийн хэрэглээ, ач холбогдлын талаарх ойлголт сайжирч тоон гарын үсэгтэй болох үйлчилгээ авч буй иргэдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байна. 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар297 иргэнд тоон гарын үсгийг шинээр олгосон ба мобайл апп -д 201 иргэнд иргэний үнэмлэхэд 96 иргэнд олгосон байна. | 100% | 100% | |
| 22 | 32 | 2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58 | XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга | Төрийн 6 байгууллага нь албан бичгийн системийг тогтмол ашиглаж харилцах байгууллагуудтайгаа цахим хэлбэрээр харилцаж хэвшсэн. Он гарсаар албан бичгийг монгол кирилл хосолсон хэлбэрээр бичиж байгууллагуудтай харилцаж байна. | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов; | | | | |
| 23 | 33 | 2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17 | XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов | Уг зөвлөмжийн хүрээнд төлөвлөгөөг боловсруулан холбогдох байгууллага, албан хаагч нарт хүргүүлж хагас жилийн хэрэгжилтийг гарган ажилласан байна. | 70% | 70% | |
| 24 | 34 | 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр 41 дүгээр тэмдэглэл 2023-10-11 Дугаар 2023_41 | XVII.1. Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлын асуудалд хяналт тавьж, хог хаягдалгүй, цэвэр орчин бүрдүүлэх үр дүнтэй арга хэмжээг шуурхай авч, хэрэгжүүлж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт | Сумын хэмжээнд хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр холбогдох хууль эрх зүйн баримт, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаж байна. 2024 онд хог ачигч машин эвдрэл гэмтэл гарсны улмаас өрхийн хог хаягдлыг ачих зөөвөрлөх ажлыг 2 сарын хугацаанд гүйцэтгэж чадаагүйгээс үүдэн хувиараа иргэд хог ачин асгасан нь хогийн цэгт хог бутарсан. Үүнийг ковш трактороор түрэх ажлыг хувийн аж ахуйн нэгжтэй хамтран 2 удаа гүйцэтгэж, хогийн цэгийн ашиглалт сайжирсан үр дүнтэй байна. Нийтийн эзэмшил газрын хог хаягдлын ерөнхий байдалд хяналтыг улирал тутамд тавьж ажиллаж байна. Бүх нийтийн их цэвэрлэгээг сар бүр тогтмол хийж хэвшсэн бөгөөд иргэд, аж ахуйн нэгжийн 120-150 иргэн хамруулж, 1,5-2 тн хог хаягдлыг сар бүр зайлуулж ажиллаж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 2 аж ахуйн нэгжид хяналт тавьж ажиллалаа. Ангилан ялгах савнууд байршуулсан, хэрэглэж хэвшсэн, Эрдэнэмонгол | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | ХХК энгийн хог хаягдлаа ангилан ялгах хог хаягдлын түр цэг байгуулан хуримтлуулж байна. | | | |
| 25 | 35 | 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны 51 дүгээр тэмдэглэл 2023-12-20 Дугаар 2023_51 | XXV.5.2. Малчдыг отор, нүүдэл хийх боломжийг бүрдүүлэх, бэлчээрийн даац, нөөц боломжид тулгуурласан отор нүүдлийн зохицуулалтыг тухай бүр хийж, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, аймаг, сумын Засаг дарга нарт даалгав | Өөр аймгийн нутагт отор хийж яваа малчидтай холбогдож мэдээ судалгааг тухай бүр авч шаардлагатай арга хэмжээг авч байна. Говьсүмбэр аймгийн Баянтал суманд Зараа багийн малчин Хүрэлсүрэн, Төв аймгийн Заамар суманд Э.Нармандах, Говь-Алтай аймгийн Чандмань суманд Т.Нармандах, өөрийн аймгийн Богд суманд Э.Данзандаржаа, Бөмбөгөр суманд Ч.Дэмбэрэл, Жинст суманд Н.Алтангэрэл нарын өрхүүд өвөлжиж хаваржин, зусаж байна. Өмнөговь аймгийн Гурвантэс сумаас өрхөөр болон тавиулаар тодорхой тооны мал өвөлжиж хаваржиж буцсан болно. Оторт яваа малчидтай байнгын холбоотой байж, өвөлжилт, хаваржилт, цаашид үргэлжлүүлэн оторлох тул нөхцөл байдлын талаар мэдээлэл солилцож хамтран ажиллаж байна. Оторт яваа малчдаас одоогийн байдлаар төрийн үйлчилгээний талаар ирсэн гомдол санал байхгүй байна. Цаг хүндэрч онцгой нөхцөл байдал үүссэн хүнд үед өөр аймаг сумын нутагт өвөлжиж хаваржиж байгаа малчиддаа 3000000 (гурван сая) төгрөгийн мөнгөн тусламжийг үзүүллээ. Зэргэлдээ Өмнөговь аймгаас отроор ирсэн малчдад төрийн үйлчилгээг хүргэн ажиллав. | 100% | 100% | |
| 26 | 36 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэл 2024-04-17 Дугаар 2024_15 | 20.11.1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд байнга ил тод, нээлттэй байлгахаар заасан мэдээллийг “Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)”-д байршуулах ажлыг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, мэдээллийг тухай бүр | https://shinejinst.bkh.gov.mn/ сайтад сумын мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны болон худалдан авах ажиллагааны талаарх мэдээллийг байршуулан ажиллаж байна. | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шинэчилж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой байгууллагуудын удирдлага, аймаг, нийслэлийн Засагдарга нарт;(Шил" ажиллагааны хэрэгжилтийн талаар ) | | | | |
| 27 | 37 | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн хуралдааны 16 дугаар тэмдэглэл 2024-04-24 Дугаар 2024_16 | 26.3.5. Шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олгохгүй байхыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт; | Шатахуун түгээх болон автомашин хийгээр цэнэглэх станцын аюулгүйн бүсийг зөрчиж газар олголт хийгдээгүй. Цаашид газар төлөвлөлт, олголт дээрээ мөрдлөг болгон ажиллаж байна. | 100% | 100% | |
| ЗГ-ын албан даалгавар | | | | | | | |
| 28 | 38 | Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай 2022-07-05 Дугаар 2022_5 | 5. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, аймаг, сумдын Засаг дарга нарт: 1.1. Улаанбаатар хот, аймаг, сумдад гэр хорооллыг хөгжүүлэх бодлогын санал боловсруулах; 1.2. Гэр хороололд сургууль, цэцэрлэг байгуулах судалгаа, төлөвлөлт, хийх, гэр хорооллын иргэдэд түргэн тусламж, гал унтраах зэрэг тусламж үйлчилгээг шуурхайг хүргэх зорилгоор гудамжны орц гарцыг сайжруулах санал боловсруулах; 1.3. Гэр хорооллын хог хаягдал, хөрсний бохирдол, жорлонгийн асуудлыг | Сумын хэмжээнд хог хаягдал хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр энгийн хог хаягдлын цэгийг шинээр байгуулах хуучин цэгийн хог хаягдлыг дарж булшлах зэрэг ажлуудыг "Эрдэнэ монгол" ХХК-ны санхүүжилтээр "Талын нөмөр" ХХК 2023 онд гүйцэтгэсэн. "Амралтаараа ажиллая" хөтөлбөрийг Эрдэнэмонгол" ХХК-тай ЗДТГ хамтран хэрэгжүүлж, 18 оюутан хамрагдсан бөгөөд хогийн цэгийн гадуур тархсан хог хаягдлыг түүх цэвэрлэх, тор хайс татах ажлыг хийж гүйцэтгэсэн. 2023 онд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газруудыг тусгаж өгсөн ба нийт 30000 мод тарих зорилттой ажиллаж байна. Сумын төвд Монголын унаган байгалийн хүлцэл тогтворжилтыг хангах нь төслийн хүрээнд мод үржүүлгийн газар бий болгож байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр модны талбай услах нарны өргүүртэй | 70% | 70% | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | шийдвэрлэх, ногоон байгууламж барих, төлөвлөгөө, шийдлийг танилцуулах. | худагтай болох хөрөнгө санхүү шийдвэрлэгдсэн зэрэг ажлууд хийгдсэн. 2024 онд гэр хорооллын хог хаягдал, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр сумын төвд 9 хэсэг нийт 2 га газарт 3060 мод шинээр тарьж суулгалаа. | | | |

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Л.БАТХУЯГ

БИЕЛЭЛТ ГАРГАСАН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Г.БАТЧИМЭГ

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

(Өөрийн үнэлгээ)

2024 оны 06 дугаар сарын 20

Залаа

| ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО | | | |
|---|---|---|---|
| Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 38 | | | |
| Үүнээс | Үр дүнтэй | **100%** | **7** |
| | Тодорхой үр дүнд хүрсэн | **70-90%** | **26** |
| | Эрчимжүүлэх шаардлагатай | **30-50%** | **4** |
| | Үр дүнгүй | **0%** | **1** |
| | Хэрэгжих хугацаа болоогүй | **Х.Б** | - |
| | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны хагас жилийн хэрэгжилт **70%** хувьтай байна. | | |

oOo

# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

(Дээд шатны байгууллагын үнэлгээ)

2024 оны 06 дугаар сарын 20 Залаа

| ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН 2024 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО | | | |
|---|---|---|---|
| Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо: 38 | | | |
| Үнээс | Үр дүнтэй | **100%** | **7** |
| | Тодорхой үр дүнд хүрсэн | **70-90%** | **26** |
| | Эрчимжүүлэх шаардлагатай | **30-50%** | **4** |
| | Үр дүнгүй | **0%** | **1** |
| | Хэрэгжих хугацаа болоогүй | **Х.Б** | - |
| | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2024 оны хагас жилийн хэрэгжилт 70% хувьтай байна. | | |

oOo